

**Х.Нямбаяр**, Магистр, МНБ,  
Мандах бүртгэл дээд сургуулийн Бүртгэл санхүүгийн тэнхмийн эрхлэгч  
nyambayar@mandakh.mn  
**Д. Золбоо**, Магистр, МНБ,  
Мандах бүртгэл дээд сургуулийн Бүртгэл санхүүгийн тэнхмийн багш  
zoloo301@yahoo.com

## **ЖИЖИГ, ДУНД АЖ АХУЙН НЭГЖИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫГ САЙЖРУУЛАХ АСУУДАЛ**

### **Abstract**

Mongolia has made significant changes in accounting to meet International Accounting Standards (IAS) since 2003. However the financial reporting system and implementation of IAS still has not been strong enough yet. The relevant matters to the issue include some challenges associated to the IAS and costs for the preparation of financial statements.

The IASB has issued IFRS for SMEs with the aim of providing customers by the appropriate guidelines on preparing financial statements in terms of making effective decisions.

Entities have a right to select the appropriate standard, which is depended on the nature of the business and follow accounting policy, which meets to the company's operation in order to improve financial reporting.

Introducing IFRS for SMEs, there are some progresses for the development of any entities such as simplifying the process of financial reporting, reducing the cost of financial statement preparation, and improving the information outputs and cost management issues. However there is a need to focus on applying the IAS with the regard of combinations in strategic planning and entity's expansion policy.

Although IFRS for SMEs simplified, it is still a kind of heavy standard for SMEs. Some issues such as differed income tax, [recoverable amount](#), measurement of fair value have still been problematic to record. Appropriate accounting methods for introducing IFRS are significantly important to issue applying glossaries and to develop accounting policy models for SME in order to improve the financial reporting of any entities.

**Key terms:** IFRS for SME, financial statement, users, accounting policy

### **Хураангуй**

Монгол улсад нягтлан бодох бүртгэлийг шинэчлэх, олон улсын стандартад нийцүүлэх ажлыг 1993 оноос үе шаттай хэрэгжүүлж ирсэн боловч одоог хүртэл санхүүгийн тайлагналын тогтолцоо сул, стандартын хэрэгжилт хангалтгүй байна. Энэ нь стандартын ашиглахад төвөгтэй байдал болон санхүүгийн тайлан бэлтгэх зардал өндөр байдагтай холбоотой.

Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл нь санхүүгийн тайлан бэлтгэх зардлыг хэмнэхийн зэрэгцээ мэдээлэл хэрэглэгчдийг эдийн засгийн оновчтой шийдвэр гаргахад шаардлагатай санхүүгийн мэдээллийг бэлтгэх удирдамжаар хангах зорилгоор жижиг дунд аж ахуйн нэгжүүдэд зориулагдсан стандартыг гаргасан.

Аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайлагналыг сайжруулж, бүртгэл хөтлөлтийн ажлыг хөнгөвчлөхийн тулд аж ахуйн нэгж нь өөрийн онцлогт тохирсон стандартыг сонгон түүндээ нийцүүлэн бодлогын баримт бичиг боловсруулан мөрдөх хэрэгтэй.

ЖДААН СТОУС-ыг нэвтрүүлснээр санхүүгийн тайлагнал хялбар болж, бүртгэл хөтлөлттэй холбоотой зардал буурч, мэдээллийн үр өгөөж болон зардлын уялдаа холбоо сайжрах боловч аж ахуйн нэгж нь тухайн стандартыг дагаж мөрдөх эсэхээ хэтийн хөгжил, цар хүрээний тэлэлттэйгээ уялдуулан шийдвэрлэх нь зохистой. ЖДААН-ийн стандарт нь хэдий хялбаршуулсан боловч жижиг аж ахуйн нэгжүүдийн хувьд томдсон стандарт юм. Хойшлогдсон татвар, хөрөнгийн бодит үнэ цэнийн хэмжилт, нөхөгдөн дүнгийн тооцоолол, тэтгэврийн төлөвлөгөөний бүртгэл зэрэг нь хүндрэлтэй хэвээр байгаа. Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлагналыг сайжруулахын тулд стандартыг нэвтрүүлэх аргачлалаар хангах, стандартын хэрэглээний тайлбар бэлтгэх, жижиг дунд аж ахуйн нэгжид зориулсан жишиг НББ-ийн бодлогын баримт бичиг боловсруулах, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын нэмэлт арга зүйгээр хангах хэрэгтэй.

*Түлхүүр үг: Жижиг дунд аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (ЖДААН-ийн СТОУС), санхүүгийн тайлан, мэдээлэл хэрэглэгч, нягтлан бодох бүртгэлийн бодлого*

## **Оршил**

Монгол улсын “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”, “Татварын ерөнхий хууль”-д зааснаар аж ахуйн нэгж, байгууллага нь олон улсын стандартад нийцсэн нягтлан бодох бүртгэл хөтөлж санхүүгийн тайлан бэлтгэх үүрэгтэй.

Манай улсад нягтлан бодох бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх ажлыг 1993 оноос үе шаттай хэрэгжүүлж ирсэн. Аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайланг загвар талаас нь харахад олон улсын стандартад нийцсэн мэт байгаа учраас олон улсын стандарт хэрэгжиж байна гэж дүгнэсээр ирсэн. Гэтэл Дэлхийн банк, Олон улсын валютын сангийн санаачилгаар хийсэн судалгаагаар санхүүгийн тайлагналын тогтолцоо сул, СТОУС-ыг хангалттай мөрддөггүй гэсэн (Б.Болормаа, 2014) дүгнэлт хийсэн байна. Жижиг дунд аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлагналыг хялбаршуулах, стандартын хэрэгжилтийг сайжруулах зорилгоор Монгол улсын “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгад 2016 оны 1 сарын 1-ээс ЖДААН СТОУС-ыг дагаж мөрдөхөөр заасан.

ЖДААН-ийн СТОУС нь гадаад мэдээлэл хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцэхүйц санхүүгийн тайлан бэлтгэхэд чиглэгдэн боловсруулагдсан. Тус стандартыг боловсруулах болсон гол зорилгыг нэгтгэн илэрхийлбэл ЖДААН-ийн санхүүгийн тайлагналыг хялбаршуулах, санхүүгийн тайлан бэлтгэх зардлыг хэмнэхийн зэрэгцээ мэдээлэл хэрэглэгчдийг эдийн засгийн оновчтой шийдвэр гаргахад шаардлагатай санхүүгийн мэдээллийг бэлтгэх удирдамжаар хангах явдал юм.

## **1. ЖДААН-ийн СТОУС, түүний онцлог**

**ЖДААН-ийн СТОУС, түүнийг боловсруулах болсон шалтгаан:** Нягтлан бодох бүртгэл нь эдийн засгийн өргөн дэлгэр мэдээллийг агуулж, эдийн засгийн шийдвэр гаргах үндэс суурь болдог учир бизнесийн харилцааны хэл ч гэж нэрлэдэг. Бизнесийн харилцааны хэл байхын тулд нягтлан бодох бүртгэл нь газар зүйн бүс нутаг, улс орны хил хязгаарт баригдахгүйгээр нэг үзэл баримтлал, нэг зарчимд суурилсан стандарт хэлбэртэй байх хэрэгтэй. Өнөөдрийн байдлаар дэлхийн 140 улс орон нягтлан бодох бүртгэлийн нэг хэв загварт шилжээд байна. (ifrs.org)

ЖДААН-ийн үндсэн мэдээлэл хэрэглэгчдэд байгууллагын удирдах үйл явцад төдийлэн оролцоод байдаггүй эзэмшигчид, банк санхүүгийн байгууллага, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагч зэрэг байдаг. Банкны хувьд байгууллагын төлбөрийн чадварын үзүүлэлтүүд, хөрөнгийн өгөөж, өрийн харьцаа, өөрийн хөрөнгийн өсөлт зэрэг үзүүлэлтүүдийг анхаардаг бол бэлтгэн нийлүүлэгчийн хувьд харилцагч байгууллагын санхүүгийн байдлын үнэлгээ зэргийг харгалздаг (НББОУСЗөвлөл, 2009).

Тухайн стандартад ЖДААН-н талаарх ойлголтыг боруулалтын орлого, хөрөнгийн хэмжээ, ажиллагсадын тоо гэх мэт үзүүлэлтүүдийн тодорхой утгаар хязгаарласан заалт байхгүй бөгөөд хамгийн гол шалгуур үзүүлэлт нь “олон нийтийн өмнө хариуцлага хүлээдэггүй байх” юм. Өөрөөр хэлбэл тус стандартад ЖДААН-ийн ерөнхий тодорхойлолт өгөгдсөн бөгөөд үүнд суурилан улс орон бүр үндэсний онцлогийг харгалзаж холбогдох байгууллагаас тогтоосон шалгуур үзүүлэлтийг мөрдөж болно. Монгол улсын хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулинд заасан.

ЖДААН-ийн СТОУС-д зааснаар жижиг дунд аж ахуйн нэгж гэж дараах аж ахуйн нэгжийг хэлнэ.

1. Олон нийтийн өмнө хариуцлага хүлээдэггүй. (Үнэт цаас гаргасан болон гаргах гэж байгаа аж ахуйн нэгж, банк, хадгаламж зээлийн хоршоо, даатгалын компани, үнэт цаасны брокер/диллер, хамтын сан болон хөрөнгө оруулалтын банкнаас бусад аж ахуйн нэгж, байгууллага)

2. Гаднын хэрэглэгчдэд зориулан ерөнхий зорилготой санхүүгийн тайлангаа хэвлүүлдэг.

Дээрх тодорхойлолтод багтсан аж ахуйн нэгж нь ЖДААН-ийн СТОУС-ыг ашиглах боломжтой бөгөөд уг стандартыг 2009 оны 07 сард гаргасан.

**Стандарт боловсруулсан зорилгын талаар:** Стандартын гол зорилго нь ЖДААН-г СТОУС-д суурилсан хялбаршуулсан арга зүйн удирдамжаар хангахад оршино. НББОУС-ын зөвлөлийн зүгээс тус стандартыг нэвтрүүлснээр СТОУС-ын хэрэглээг Европын төдийгүй

дэлхийн бүх улс оронд түгээн дэлгэрүүлэхэд чухал нөлөө үзүүлнэ гэж тооцоолсон. Учир нь СТОУС-ын практик хэрэглээг нэмэгдүүлэхэд саад учруулж байгаа хүчин зүйлсийн нэгээхэн хэсэг нь СТОУС-ын ашиглахад төвөгтэй байдал болон түүний дагуу санхүүгийн тайлан бэлтгэхэд зардал ихээхэн шаардагддаг зэрэг юм. Үүнээс гадна СТОУС нь байгууллагын нягтлан бодогч болон аудитораас мэдлэг, мэргэжлийн өндөр түвшинг шаардахуйц тооцоолол гүйцэтгэх, заалтуудыг хэрэглэхийг шаарддаг. Энэ нь зарим тохиолдолд санхүүгийн тайлангийн мэдээллийн бодит байдалд сөргөөр нөлөөлдөг.

ЖДААН-ийн СТОУС нь гадаад мэдээлэл хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцэхүйц санхүүгийн тайлан бэлтгэхэд чиглэгдэн боловсруулагдсан. ЖДААН-ийн үндсэн мэдээлэл хэрэглэгчдэд байгууллагын удирдах үйл явцад төдийлэн оролцоод байдаггүй эзэмшигчид, банк санхүүгийн байгууллага, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагч зэрэг байдаг. Банкны хувьд байгууллагын төлбөрийн чадварын үзүүлэлтүүд, хөрөнгийн өгөөж, өрийн харьцаа, өөрийн хөрөнгийн өсөлт зэрэг үзүүлэлтүүдийг анхаардаг бол бэлтгэн нийлүүлэгчийн хувьд харилцагч байгууллагын санхүүгийн байдлын үнэлгээ зэргийг харгалздаг.

#### **Тухайн стандартын гол зорилго нь:**

- ЖДААН-ийн нягтлан бодох бүртгэлд тавигдах шаардлагыг хялбаршуулах
  - ЖДААН-ийн санхүүгийн тайлан бэлтгэхтэй холбоотой зардлыг бууруулах
  - Мэдээлэл хэрэглэгчдэд эдийн засгийн шийдвэр гаргахад шаардлагатай, ЖДААН-ийн онцлогыг харгалзсан санхүүгийн мэдээллээр хангах
- СТОУС-ын хэрэглээг дэлгэрүүлэх зэрэг болно.

Тус стандартыг боловсруулах болсон гол зорилгыг нэгтгэн илэрхийлбэл санхүүгийн тайлан бэлтгэх зардлыг хэмнэхийн зэрэгцээ мэдээлэл хэрэглэгчдийг эдийн засгийн оновчтой шийдвэр гаргахад шаардлагатай санхүүгийн мэдээллийг бэлтгэх удирдамжаар хангах болно. Тухайлбал хэмжилтийг дараах байдлаар хялбаршуулсан.

1. Уг стандартаар ихэнх элементүүдийг анхны өртгөөр нь хэмждэг. Гэхдээ хөрөнгийг түүний борлуулалт эсвэл ашиглалтаас нөхөхөөр хүлээгдэж байгаа дүнгээс илүү дүнгээр хэмжихгүй.

2. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, биологийн хөрөнгө, зарим санхүүгийн хэрэглүүрин хувьд илүү зардал, хүчин чармайлт гаргахгүйгээр бодит үнэ цэнийг тодорхойлох боломжтой бол бодит үнэ цэнээр нь хэмжинэ.

#### **ЖДААН-ийн СТОУС-ын бүтэц, агуулга**

##### **1. Үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг аккруэл суурь, тасралтгүй байх зарчмыг баримтлан бэлтгэнэ.

*Санхүүгийн тайлангийн зорилго нь* мэдээлэл хэрэглэгчдийг эдийн засгийн шийдвэр гаргахад ашиглах санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээний тухай мэдээллээр хангахад оршино.

*Санхүүгийн тайлангийн шинжүүд:* ойлгомжтой, зохистой, материаллаг, найдвартай, хэлбэрээс мөн чанарыг илүүд үзсэн, хянамгай, иж бүрэн, зэрэгцүүлэх боломжтой, цаг хугацаандаа, өгөөж болон өртгийн тэнцвэрийг хадгалсан.

##### **2. Хэмжилт**

*Анхны өртөг:* Уг стандартаар ихэнх санхүүгийн тайлангийн элементүүдийг анхны өртгөөр нь хэмждэг. Гэхдээ хөрөнгийг түүний борлуулалт эсвэл ашиглалтаас нөхөхөөр хүлээгдэж байгаа дүнгээс илүү дүнгээр хэмжихгүй.

*Бодит үнэ цэнэ:* Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, биологийн хөрөнгө, зарим санхүүгийн хэрэглүүрийг бодит үнэ цэнээр хэмжих шаардлага гарч болно.

##### **3. Анх удаа хэрэгжүүлэх нь**

СТОУС-ыг анх удаа хэрэгжүүлэгч тал ЖДААН-ийн СТОУС-д нийцүүлэн санхүүгийн тайлангаа бэлтгэж байгаа бол энэ тухайгаа мэдээлэх ёстой.

Аж ахуйн нэгж нь өмнөх үеүдэд санхүүгийн тайлан гаргаж байгаагүй, өмнө гаргаж байсан тайлан нь иж бүрэн СТОУС-д нийцэж байсан эсвэл өөр НББНХЗЗ-ын дагуу тайлан гаргаж байсан бол анх удаа хэрэгжүүлэгч гэж үзнэ.

Аж ахуйн нэгж зэрэгцүүлсэн мэдээллийг өмнөх үеийн нэг ба түүнээс дээш зэрэгцүүлэгдэх хугацаагаар толилуулна. *ЖДААН-ийн СТОУС*-д шаардсаны дагуу бүх хөрөнгө, өр төлбөрөө хүлээн зөвшөөрнө. СТОУС-аар зөвшөөрөгдөөгүй хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй,

СТОУС-д нийцсэн анхны санхүүгийн тайлангаа гаргахдаа дараах чөлөөлөлтийг эдлэнэ. Үүнд: Бизнесийн нэгдэл, хувьцаанд суурилсан төлбөр бүхий ажил гүйлгээ, бодит үнэ цэнээр болон дахин үнэлсэн дүнгээр тусгасан эргэлтийн бус хөрөнгө, хуримтлагдсан хөрвүүлэлтийн зөрүү, тусдаа санхүүгийн тайлан, санхүүгийн нийлмэл хэрэглүүр, хойшлогдсон орлогын албан татвар, олборлох үйл ажиллагаа зэрэг орно.

#### 4. НББ-ийн бодлогын сонголт

Хэрэв СТОУС-д аливаа ажил гүйлгээ, үйл явдлыг тусгайлан авч үзээгүй бол тухайн аж ахуйн нэгжийн удирдлага дараах шинжийг агуулсан мэдээлэл бий болгохуйц нягтлан бодох бүртгэлийн бодлогыг боловсруулж ашиглах хэрэгтэй.

-Хэрэглэгчийн эдийн засгийн шийдвэр гаргах хэрэгцээнд хамааралтай

-Санхүүгийн тайланд тусгагдсан зүйлс нь найдвартай

СТОУС-д тусгайлан шаардсан эсвэл аливаа зүйлийн ангиллын хувьд нягтлан бодох бүртгэлийн ялгаатай бодлого ашиглах нь тохиромжтой байхаас бусад тохиолдолд аж ахуйн нэгж ижил төстэй ажил гүйлгээ, бусад үйл явдал, нөхцөл байдлыг бүртгэхдээ нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тууштай хэрэглэх ёстой.

#### 5. Санхүүгийн тайлан

А. Санхүүгийн байдлын тайлан: Дараах зүйлсийг тусгасан байх хэрэгтэй.

Б. Дэлгэрэнгүй орлогын тайлан ба орлогын тайлан

В. Өмчийн өөрчлөлтийн тайлан ба орлого хуримтлагдсан ашгийн тайлан

Г. Мөнгөн гүйлгээний тайлан

Д. Санхүүгийн тайлангийн тэмдэглэл

#### 2. ЖДААН-н санхүүгийн тайлагналыг сайжруулах асуудал

Аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайлагналыг сайжруулж, бүртгэл хөтлөлтийн ажлыг хөнгөвчлөхийн тулд аж ахуйн нэгж нь өөрийн онцлогт тохирсон стандартыг сонгон түүндээ нийцүүлэн бодлогын баримт бичиг боловсруулан мөрдөх хэрэгтэй.

Иж бүрэн СТОУС болон ЖДААН-ийн СТОУС нь агуулгын хувьд дараах ялгаатай.

Хүснэгт 2.1 СТОУС-ын агуулгын өөрчлөлт

№	Үзүүлэлт	Ялгаа
1	Санхүүгийн хэрэглүүр	Санхүүгийн хэрэглүүрийг дараах 2 бүлэгт ангилсан: -Анхны өртгөөр эсвэл хорогдуулсан өртгөөр хэмжих -Бодит үнэ цэнээр хэмжих /бодит үнэ цэнийн зөрүүг үйл ажиллагааны үр дүнд шингээх/ Үүнээс гадна санхүүгийн хөрөнгийг данснаас хасах болон хейджийн бүртгэлийг харьцангуй хялбаршуулсан.
2	Хамтарсан үйлдвэр дэх хөрөнгө оруулалтын бүртгэл	Тухайн стандартад дараах 3 аргыг санал болгосон: Өртгийн заргвар Өмчийн арга Бодит үнэ цэнийн арга Хамтын хяналттай компаниудын хувьд ашиглагдах хувь
3	Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт	Хэрэв байгууллага ойрын 1 жилийн хугацаанд борлуулах зорилгогүй охин компанид хөрөнгө оруулсан бол нэгтгэсэн санхүүгийн тайланд тухайн охин компанид харьяалагдах бүхий л зүйлсийг тусгаж өгнө. Хэрэв толгой компани СТОУС болон ЖДААН-ийн СТОУС-ын дагуу нэгтгэсэн тайлан бэлтгэдэг охин компаниуд дээрх хариуцлагыг үүрэхгүй.
4	Гуудвилл болон бусад ашиглах хугацаа нь	Хэрэв тухайн байгууллага гуудвилл болон бусад биет бус хөрөнгийн ашиглах хугацааг тодорхойлох боломжгүй бол 10 жилээр тооцож хорогдуулна. Энэ хугацаа нь биет бус хөрөнгийг хэт өндөрөөр үнэлэхээс сэргийлсэн хэрэг юм. Үүнээс гадна байгууллага жил бүр

	тодорхойгүй биет бус хөрөнгийн бүртгэл	гуудвилл болон бусад ашиглах хугацаа нь тодорхойгүй биет бус хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг тестлэн үзэх шаардлагатай бөгөөд хэрэв тийм шинж илэрсэн гэж үзвэл нөхөгдөх дүнг тодорхойлно. Харин СТОУС-д нөхөгдөх дүнг жил бүр тодорхойлж байхыг заасан байдаг.
5	Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө	Үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгийг анхны өртгөөр нь үнэлж бүртгэх бөгөөд байгуулсан хуримтлагдсан элэгдлийг болон үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр тайлагнахаар заасан. Ашиглах хугацаа, элэгдүүлэх арга зэргийг зөвхөн тухайн хөрөнгийн ашиглалтанд материаллаг өөрчлөлт гарсан үед өөрчлөх боломжтой гэж тодорхойлсон.
6	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	Тухайн хөрөнгийг анхны өртөг болон бодит үнэ цэнийн аль нэгнээр үнэлнэ. Тухайн үнэлгээ нь НББ-ийн бодлогоос бус харин хөрөнгийг хэрхэн ашиглаж байгаа буюу нөхцөл байдлаас шалтгаална.
7	Зээлийн зардал	Зээлийн зорилгоос үл хамааран холбогдох зардлыг тайлант хугацааны зардлаар хүлээн зөвшөөрнө.
8	Засгийн газрын буцалтгүй тусламж	ЗГ-ын буцалтгүй тусламжийг орлогоор хүлээн зөвшөөрнө. НББОУС 20-оор ЗГ-ын буцалтгүй тусламжийг бүртгэх олон төрлийн аргуудыг зөвшөөрдөг.
9	Судалгаа хөгжүүлэлтийн зардал	Тайлант хугацааны зардлаар хүлээн зөвшөөрнө.
10	Хувьцаанд суурилсан төлбөр	Практик боломжтой бол бодит үнэ цэнээр нь хэмжинэ. Бодит үнэ цэнийг тодорхойлох боломжгүй бол ААН-ийн удирдлага хамгийн тохиромжтой гэж үзсэн үнэлгээний аргыг хэрэглэж болно.
11	Ажилчдын тэтгэвэр тэтгэмж	Тэтгэвэр, тэтгэмжийн тогтоосон төлөвлөгөөнд дараах зүйлийг хялбаршуулсан. Цалингийн ирээдүйн тооцоолсон өсөлтийг үл хэрэгсэх, одоогийн ажиллагсдын ирээдүйн үйлчилгээг үл хэрэгсэх, ажиллагсдын нас барах магадлалыг үл хэрэгсэх.

Эх сурвалж: Источник: Журнал "Корпоративная финансовая отчетность: Международные стандарты" №8, 2009

2015 оны 06 сард дараах гол өөрчлөлт орсон ба 2017.01.01-с мөрдөнө.

1. Үндсэн хөрөнгийн дараа үеийн үнэлгээ-Дахин үнэлгээний загвар сонгох боломжтой болсон.
2. Хойшлогдсон татварын хүлээн зөвшөөрөлт, хэмжилт шаардлагууд өөрчлөгдсөн.
3. Хайгуул үнэлгээний хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт, хэмжилтийн шаардлагууд өөрчлөгдсөн.

Тус стандартыг нэвтрүүлэхтэй холбоотойгоор Европын холбооны улсуудад явуулсан судалгаагаар дараах дүгнэлтэд хүрсэн байна.

#### Хүснэгт 2.2 СТОУС нэвтрүүлснээр гарах үр дагавар

№	Эерэг хандлага	Сөрөг хандлага
1	Хууль эрх зүйн янз бүрийн орчинд үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын санхүүгийн тайлангуудыг зэрэгцүүлэх боломжтой, цаашлаад олон улсын худалдаа, хамтын ажиллагаа хөгжихөд чухал нөлөө үзүүлнэ	Хэдийгээр ЖДААН-ийн СТОУС нь СТОУС-ын бүрэн хувилбартай харьцуулахад хялбаршуулсан боловч төвөгтэй хэвээр үлдсэн. Зөвхөн дотооддоо үйл ажиллагаа явуулдаг өөрөөр хэлбэл өөр гадны компанитай санхүүгийн тайлангаа зэрэгцүүлэх хэрэгцээ шаардлага байхгүй байгууллагын хувьд тухайн бүртгэл хөтлөлттэй холбоотой зардал нь холбогдох санхүүгийн мэдээллийн өгөөжөөс давж болох талтай.
2	Бусад улс оронд охин компани бүхий байгууллагын хувьд нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэх үйл явцыг харьцангуй хялбар болно.	Стандартыг нэвтрүүлснээр тухайн байгууллагын бүртгэлийн ажилтнууд болон аудиторуд харьцуулагдах мэдээллийг дахин тооцоолох шинэ арга зүй, системд суралцах шаардлага үүснэ.

		Мэргэжлийн нягтлан бодогчгүй дийлэнх жижиг аж ахуйн нэгжүүдийн хувьд стандарт өөрчлөгдөх бүрт зөвлөгөө авахаар холбогдох үйлчилгээний байгууллагуудад хандаж нэмэлт зардал үүсгэхэд хүрнэ.
3	Аудитын үйлчилгээтэй холбоотой зардал багасах, Европын улсуудын хүрээнд нягтлан бодогчдын шилжилт хөдөлгөөн нэмэгдэх	Бүртгэл хөтлөлтийн төвөгтэй байдал аудиттай холбоотой зардлыг нэмэгдүүлэхэд хүрдэг. Түүнээс гадна байгууллагууд хойшлогдсон татвар, хөрөнгийн бодит үнэ цэнийн хэмжилт, нөхөгдөн дүнгийн тооцоолол, тэтгэврийн төлөвлөгөөний бүртгэл зэрэг асуудлуудтай холбоотой зөвлөх үйлчилгээ ямагт хэрэгцээтэй.
4	Хөрөнгийн өртөг буурна.	Тухайн стандарт дотоод удирдлагын зорилгод нийцэхгүй бөгөөд нэмж тодруулах шаардлагатай мэдээлэл нь байгууллагын өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлөх боломжтой.

Эх сурвалж: Журнал "Корпоративная финансовая отчетность: Международные стандарты" №5, 2013

### Дүгнэлт

ЖДААН СТОУС-ыг хүлээн зөвшөөрч нэвтрүүлснээр санхүүгийн тайлагнал хялбар болж, бүртгэл хөтлөлтэй холбоотой зардал буурч, мэдээллийн үр өгөөж болон зардлын уялдаа холбоо сайжрах боловч ЖДААН нь тухайн стандартыг дагаж мөрдөх эсэхээ хэтийн үйл ажиллагааны хөгжил, цар хүрээний тэлэлттэйгээ уялдуулан шийдвэрлэх нь зохистой. Учир нь тухайн байгууллагын цар хүрээ өргөжиж СТОУС-ыг хэрэглэх шаардлага бий болох үед стандартыг нэвтрүүлэхтэй холбоотой асуудал дахин үүсэхэд хүрэх талтай. Өөрөөр хэлбэл мэдээлэл хэрэглэгчдийн хүсэл сонирхлыг харгалзан үзэх хэрэгтэй. Хэрэглэгч нь иж бүрэн стандартад нийцсэн мэдээллийг сонирхож болох юм.

СТОУС-г мөрдөж байсан аж ахуйн нэгж ЖДААН-ийн СТОУС-т шилжихэд хүндрэлтэй асуудал бага боловч СТОУС-ыг мөрддөггүй байсан аж ахуйн нэгжүүдийн хувьд хүндрэл үүсч болно.

Уг стандарт нь хэдий хялбаршуулсан боловч жижиг аж ахуйн нэгжүүдийн хувьд томдсон стандарт юм. Өөрөөр хэлбэл уг стандарт нь дунд хэмжээний аж ахуйн нэгжүүдэд зориулагдсан. Хойшлогдсон татвар, хөрөнгийн бодит үнэ цэнийн хэмжилт, нөхөгдөн дүнгийн тооцоолол, тэтгэврийн төлөвлөгөөний бүртгэл зэрэг нь хүндрэлтэй хэвээр байгаа.

### Санал

- Мэргэжлийн их дээд сургуулиуд, мэргэжлийн байгууллагууд ЖДААН-ийн СТОУС-г нэвтрүүлэх аргачлалаар хангах, стандартын хэрэглээний тайлбар бэлтгэх.

- Жижиг дунд аж ахуйн нэгжид зориулсан жишиг НББ-ийн бодлогын баримт бичиг боловсруулах

- Үндсэн хөрөнгийн бий болгох эдийн засгийн өгөөжийн хэмжээ, үлдэх өртөг, элэгдэл тооцох аргыг сонголт, бодит үнэ цэнийн хэмжилт, нөхөгдөх дүн, өнөөгийн үнэ цэнийн тооцоолол зэрэгт нэмэлт арга зүйгээр хангах

### Ном зүй

1. *ifrs.org*. (2015). <http://www.ifrs.org/Use-around-the-world/Pages/Jurisdiction-profiles.aspx>
2. А.В., Б. (2015). Основы трансформации отчетности малых и средних предприятий в отношении МСФО №9. *Аудит*.
3. Анна, Ю. (2013 оны 10 08). [www.audex.ru](http://www.audex.ru).
4. Б.Болормаа. (2014). *Некоторые вопросы по внедрению международных стандартов финансовой отчетности в предприятиях*. Улаанбаатар хот.
5. В.Е., Ш. (2013). МСФО для предприятий малого и среднего бизнеса. *Корпоративная финансовая отчетность. Международные стандарты №5*.
6. Совет по МСФО. (2009). *МСФО для МСП*.
7. Совет по МСФО. (2015). *МСФО для МСП изменения, дополнения*.
8. Ю.В., Б. (2009). МСФО для малых и средних предприятий. *Корпоративная финансовая отчетность. Международные стандарты №8*.

